

## Тойм

2021 оны 10 сард Эрдэнэ Ресурс Девелопмент Корп. нь Монголын Хөрөнгийн Биржид нэмж үнэт цаас гарган, хөрөнгө оруулалт татсан. Энэхүү хугацаанаас хойш 6 сарын хугацаанд Эрдэнэ Ресурс өндөр үр бүтээлтэй ажилласныг дуулгахад таатай байна.

2021 оны санхүүгийн тайлант 12 сарын хугацаанд бид Баян Хөндий Төслийг хөгжүүлэлтийн шат руу хүргэх, дэлхийн алтны ил уурхайн төслүүдтэй харьцуулахад агуулга болон хөрөнгө оруулалтын өгөөж илүү болохыг нь тодорхойлж, мэдээ мэдээллийг хөрөнгө оруулагчдадаа тухай бүр хүргэж ажиллав. Хөндий Алтны Дүүргийн гол онцлог нь дэлхийн томоохон алтны ордуудыг агуулагч бүсэд хамаарагдах бөгөөд туршлагатай техникийн багийн ур чадвар, мэдээлэлд тулгуурлан энэ бүс нутагт цаашид шинэ нээлтүүд илрүүлэх боломжтойд оршино.

Түүнчлэн Баян Хөндий Алтны Төслийг хөгжүүлэхэд төвлөрөхийн сацуу Хөндий Алтны Дүүрэгт хайгуулын ажлуудыг үргэлжлүүлэв. Энэхүү дүүрэг нь суурь, үнэт металлын эрдэсийн хуримтлал, зэс-молибденийн порфирууд, дундаж сульфиджилттэй карбонат суурь металлын алтны ордууд болон бага сульфиджилттэй эпитеpmаль алт ба алт-мөнгөний системүүдийг багтаадаг. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд бид Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хамгийн их мэдээллийг агуулсан хувийн геологийн мэдээллийн санг бүрдүүлж, 20 гаруй хэтийн төлөвтэй талбайг тодорхойлоод байна. Бидний тооцооллоор энэхүү дүүрэгт хөрөнгө оруулагчдын үнэ цэнийг нэмэгдүүлэх онцлог нээлтүүдийг хийх боломжтой.

## Хайгуул ба хөрөнгө оруулалт

Хөндий Алтны Дүүрэг нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг. Энэхүү бүсэд системт геологи хайгуулын ажил хязгаарлагдмал хийгдэж байсан бөгөөд бид энэхүү бүс нутагт анхдагч болсон юм. Бидний төвлөрсөн бүс нутагт буюу Хөндий Алтны Дүүргийн хоёр ордод хийсэн өрөмдлөгийн ажлууд нь газрын гадаргаас доош 150 метрээр хязгаарлагдаж байсан хэдий ч энэхүү үр дүнгүүдэд тулгуурлан ирээдүйд шинээр нээлтүүд хийгдэх боломжтой.

2021 онд компани нь Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд өрөмдлөгийн хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн. Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрөөр Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Хар Морийн Дэл бүс, Улаан тусгай зөвшөөрлийн талбайд Зүүн Өмнөд Улаан бүсийг шинээр нээв.

Бид цаашид тусгай зөвшөөрлийн талбайд нэмэлт хайгуул хийх, бүс нутаг дахь тусгай зөвшөөрлийн талбайг нэмэх зэргээр нөөцийг нэмэгдүүлэх боломжуудыг тодорхойлсоор байна. Тодорхой бүс нутагт хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцохоор төлөвлөсөн. Мөн энэхүү бүсэд улсын төсвийн хөрөнгөөр геологийн зураглал хийгдэж байгаа нь Монгол Улсын баруун өмнөд бүс дэх хэтийн төлөв бүхий талбайд тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцох боломжуудыг нээж байна.

## Санхүүгийн байдал

Бид 2021 оны 10-р сард 5 сая ам.доллартай дүйцэх хөрөнгийг Монголын Хөрөнгийн Биржээс татан төвлөрүүлсэн. Энэхүү хөрөнгийг Баян Хөндий төслийн хөгжүүлэлт, бүтээн байгуулалтын бэлтгэл ажлууд, тусгай зөвшөөрлийн талбайд өрөмдлөгийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэхэд зарцуулсан.

Дээрх зардлуудын дийлэнх хэсгийг геологийн судалгаа, өрөмдлөгийн зардал болон хээрийн үйл ажиллагааны зардлууд бүрдүүлдэг. Баян Хөндий төсөл нь олон улсын болон дотоодын ТЭЗҮ бүрэн хийгдэж холбогдох байгууллагуудаар баталгаажихын сацуу олон улсын болон дотоодын зохицуулах шаардлагуудыг хангасан Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан үнэлгээ хийгдэж холбогдох байгууллагуудаар баталгаажуулсан болно. Баян Хөндий төсөл нь хоногт 1,800 тонн хүдэр боловсруулах ба жилд дундажаар 2 тонн алт олборлож Монголбанканд тушаах хүчин чадалтайгаар төлөвлөгдсөн.

Эрдэнэ Ресурс нь одоогоор Баян Хөндий Алтны Төслийг олборлолтын шат руу шилжүүлэн өндөр агуулга бүхий ил уурхай хөгжүүлэх, Баян Хөндий Алтны Төслийн суурь болон үнэт металлын нөөцийг нэмэгдүүлэх хайгуулын судалгааг хийх хоёр үндсэн зорилттой ажиллаж байна. Бид цаашид Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлт, өсөлтөд тулгуурлан хөрөнгө оруулагчдадаа бодит үнэ цэнийг бий болгоно.

### Хайгуул үнэлгээний хөрөнгө

Компанийн Монгол улс дахь ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг Компанийн охин компаниуд болох Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресорзис ХХК, Лидер Эксплорэйшн ХХК эзэмшдэг. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүд нь гурван жилийн хугацаанд хүчинтэй байх ба хугацааг 12 хүртэл жилээр сунгах боломжтой. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгодог бөгөөд 20 хүртэл жилээр 2 удаа сунгах боломжтой. Тусгай зөвшөөрлүүдийн жилийн төлбөрийг төлснөөр тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байна.

### Хөндий Алтны Дүүрэг

Хөндий Алтны Дүүрэг нь Монгол Улсын Баянхонгор аймагт, 2,309 га ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай, 2,205 га Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай, 1,780 га талбайг хамрах Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай болон алт, мөнгө, цайр, хар тугалгын нөөц бүхий Алтан Нар ордыг агуулсан 4,669 га Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг хамарч оршдог.

2019 оны 8 сарын 5-нд Монгол улсын Ашигт Малтмал Газрын Тосны Газар (“АМГТГ”)-аас Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн тодорхой хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон. Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Тетра Тек-ийн боловсруулж, 2018 оны 12 сарын 4-нд олон нийтэд танилцуулсан “Khundii Gold Project, NI 43-101 Technical Report” нэртэй тайлан дахь Баян Хөндийн геологийн ба үйлдвэрлэлийн нөөцийг багтаасан. Түүнээс гадна ашиглалтын тусгай зөвшөөрөлд Эрдэнэ Ресурсийн Хар Морь, Алтан Сум, Хойд Хөндий, Баруун Хөндий зэрэг хэтийн төлөв бүхий талбай багтдаг.

Компани нь 2016 оны 7 сарын 1-ээс капиталын бодлогын дагуу хайгуулын зардлыг капиталжуулж эхэлсэн. Үүнээс өмнө зөвхөн Баян Хөндий тусгай зөвшөөрлийн төлбөрийг капиталжуулж байсан.

2020 оны 3 сарын 5-нд Ашигт Малтмал Газрын Тосны Газар Цэнхэр Номин хайгуулын тусгай зөвшөөрлийг Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл болгон бүртгэсэн. 2015 оны 1 сарын 1-нд Алтан Нарын анхан шатны нөөцийн тооцооллыг гүйцэтгэсэн бөгөөд Компани нь капиталын бодлогын дагуу хайгуулын зардлыг капиталжуулж эхэлсэн. Компани нь 2015

оноос өмнө зөвхөн Алтан Нартай холбоотой тусгай зөвшөөрлийн төлбөрийг капиталжуулж байв.

### Зуун Мод/ Хөвийн Хар

Зуун Мод төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт байрладаг. 6,041 га талбайг хамарсан тусгай зөвшөөрлийн талбайд молибден-зэсийн нөөц бүхий орд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд авсан бөгөөд энэхүү тусгай зөвшөөрөл нь 30 жилийн хугацаанд хүчинтэй, цаашид 20 жилийн хугацаатайгаар 2 удаа сунгах боломжтой.

Молибденийн зах зээлийн үнэ өнгөрсөн жил тодорхой хэмжээгээр өссөн бөгөөд Эрдэнэ Ресурс нь Зуун Мод зэс-молибденийн төслийн стратегийн үнэлгээг эхлүүлээд байна.

### Улаан ба бусад

Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайтай хил залгаа, нийт 1,780 га талбайг хамардаг. 2017 оны 3-р улиралд Эрдэнэ Ресурс нь Лидер Эксплорэйшн ХХК -ийн 51%-ийг худалдаж авсан бөгөөд 2020 оны 4-р улиралд үлдсэн 49%-ийг худалдан авч, 100% эзэмших болсон.

### 2021 оны 4-р улирлын байдлаар хөрөнгийн зарцуулалтын мэдээлэл

Үйл ажиллагаа	CAD	%	MNT
Захиргааны зардал	964,298	13%	2,182,601,736
Хөрөнгө татан төвлөрүүлэхэд зарцуулсан зардал	577,683	8%	1,307,533,479
Хөрөнгийн зардал	154,882	2%	350,561,468
<b>Үйл ажиллагаанд</b>			
Хээрийн ажлууд	488,755	7%	1,106,253,815
Өрөмдлөг ба дээжлэлтийн ажлууд	657,320	9%	1,487,784,978
Цалин	594,434	8%	1,345,448,324
Бусад	33,029	0%	74,757,569
<b>Баянхөндий төслийн хөгжүүлэлт</b>			
Хээрийн ажлууд	488,755	7%	1,106,253,815
Цалин	594,434	8%	1,345,448,324
Төслийн судалгаа шинжилгээний ажлууд	1,218,746	17%	2,758,521,476
Орон нутаг дах үйл ажиллагаа болон бусад	1,145,912	16%	2,593,669,427
Төслийн санхүүжилт, түүнтэй холбоотой судалгааны ажлууд	212,361	3%	480,660,011
Бусад	33,029	0%	74,757,569
<b>Нийт</b>	<b>7,163,639</b>	<b>100%</b>	<b>16,214,251,991</b>

2021 оны компанийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон үйл ажиллагааны тайлантай компанийн вебсайт болон МХБ-ийн вебсайтаас танилцана уу.

### Үр дүн

Эрдэнэ Ресурс нь 2018 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр давхар бүртгүүлэн, 1 сая ам.долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн. 2021 онд нэмж үнэт цаас гарган 5 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлж, Баян Хөндий төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажил болон хайгуул, ерөнхий зардалд зарцуулахаар төлөвлөн,

танилцуулсан. Компани энэхүү төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийг хийн, жилийн эцсийн санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлангаар танилцуулсан.

### Баян Хөндий төсөл хөгжүүлэлт, бүтээн байгуулалтын бэлтгэл ажлууд

2021 оноос эхлэн компани нь Баян Хөндий төсөл хөгжүүлэлт болон бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг гүйцэтгэж ирсэн бөгөөд 2022 оны 2-р улирлаас барилгын тодорхой ажлуудыг эхлүүлэхээр төлөвлөсөн. Үүнд төслийн талбайд ажилтнуудын хотхоныг өргөтгөн, 2 га талбайд ургамалжуулалтын талбайг байгуулсан. Түүнээс гадна 2021 оны эцэст компани Баян Хөндий Алтны Төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг (БОННУ)-г Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-аар батлуулсан. Боловсруулах үйлдвэрээс бусад байгууламжийн зураг төсөл эцсийн байдлаар батлагдсан.

Компани нь төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, барилгын ажлыг гүйцэтгэснээр орон нутагт шинээр ажлын байр бий болгох ач холбогдолтой. 2021 онд бид төсөл хэрэгжих орон нутагт ажлын байрны чиглэл олгох сургалт, ажлын байрны өдөрлөг, орон нутгийн иргэдийг мэргэшүүлэх сургалтуудыг холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэснээр өдгөө 60 гаруй шинэ ажлын байрыг орон нутагт бий болгоод байна.

2022 онд барилгын үйл ажиллагааг бүрэн эхлүүлж чадвал 2023 оны 4-р улиралд анхны бүтээгдэхүүн гаргах боломжтой хэмээн төсөл хөгжүүлэлтийн хуваарьт тусгагдсан. Монгол Улсын хил гаалиар барилгын болон үйлдвэрийн тоног төхөөрөмжийг хугацаанд нь татан авахад хүндрэл үүсвэл анхны бүтээгдэхүүн 2024 онд гарахаар болж хойшилно. Өнөөдрийн байдлаар урт хугацаа шаардагдах гол тоног төхөөрөмжүүдийн нэг болох хагас өөрөө нунтаглагч (SAG) тээрэм болон бөмбөлөгт (Ball) тээрэм нийлүүлэх гэрээг БНХАУ-ын CITIC компанитай байгуулан, 1.8 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөр төлж, захиалга хийгдсэн. Мөн алтны өрөөний тоног төхөөрөмжийг нийлүүлэх гэрээг БНӨАУ-ын СОМО компанитай байгуулж, захиалгын урьдчилгаа төлбөр төлөгдсөн.

### Хайгуулын үр дүнгүүд (2021 онд гүйцэтгэсэн хайгуулын онцлох үр дүнгүүд)

#### Бүс нутгийн хайгуул

Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд шинэ өндөр агуулга бүхий бүсийг нээн илрүүлж, Хар Морийн Дэл хэмээн нэрлэсэн.

- Хар Морийн Дэл бүсийн урд зүгт гүйцэтгэсэн өрөмдлөгийн ажлаар өргөн, газрын дөт гүнд (100 метрийн гүнд), бага агуулга бүхий алтны бүсүүдийг баталгаажуулсан.
- Өнөөг хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр Хар Морийн Дэл бүс дэх 1.5 км-ийн хувирлын тренд, алтны эрдэсжилт нь өмнө хойд суналын дагуу нээлттэйг тогтоосон. Газрын дөт гүнд, исэлдсэн, суперген алтны эрдэсжилт нь өмнө зүгт 350 метр, хойд зүгт 500 метр үргэлжилж буй нь тодорхойлогдсон.

Улаан тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн хайгуулын өрөмдлөгөөр шинэ нээлт хийсэн:

- Өнөөдрийг хүртэл хийсэн хайгуулын хөтөлбөрүүдийн үр дүнгээс харахад Хөндий-Улаан хувирлын систем болон алтны илрэлүүд илэрсэн энэхүү том алт агуулагч гидротермаль систем нь бүрэн судлагдаагүй хэвээр байна.
- Өнөөг хүртэл тогтоогдсон алтны эрдэсжилт нь Хөндий-Улаан гидротермаль хувирлын системийн хязгаарын дагуу тэлсэн цагаан гялтгануур ба цахиураар

хувирсан туфын үед байрлаж байна. Кварцын судал, шаврын хувирлын бүтцээс харахад Хөндий-Улаан системд томоохон эпитеpmаль хэв шинжийн алтны эрдэсжилтийг агуулж, литологи нь алтны эрдэсжилтийг бүрдүүлэх таатай орчинг бий болгосон гэж үзэж байна.

### Баян Хөндий төслийн санхүүжилтийн төлөвлөгөө

2020 онд олон улсын хөрөнгө оруулагчдад танилцуулсан ТЭЗҮ-д Баян Хөндий төслийн анхны хөрөнгө оруулалт нь 59 сая ам.доллар байхаар тусгагдсан. Төслийн санхүүжилтийн дийлэнх хэсэг болох 55 сая ам.долларыг Канад Улсын Export Development Canada (Канадын Экспорт Хөгжлийн Агентлаг) хэмээх засгийн газрын санхүүжүүлэгч байгууллагаас татан төвлөрүүлэхээр зээлийн судалгааг дуусгасан бөгөөд одоогоор санхүүжилтийн нөхцөлүүдийг хэлэлцэж байна. Зээлийн санхүүжилтээс бусад шаардлагатай санхүүжилтийг Эрдэнэ Ресурс Девелопмент Корп олон улсын болон дотоодын хувьцааны хөрөнгө оруулагчид болон бусад санхүүжилэгч байгууллагуудаас татан төвлөрүүлэх судалгаа хийж байна.